



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/10


Батширээт сум

**Эрхийн бичиг олгох ажилтан
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2, 28 дугаар зүйлийн 28.2.2, 28.2.3, Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутаг дэвсгэрт ахуйн зориулалтаар ан агнах, загас барих эрхийн бичгийг зохих журмаар олгож, төлбөр хураамжийг төвлөрүүлэн ажиллах эрх бүхий ажилтнаар Байгаль хамгаалагч Б.Болд, Б.Тулга, Б.Сансармаа нарыг томилсугай.
2. Тухайн жилийн батлагдсан хуваарийн дагуу эрхийн бичиг олголт, агнуурын нөөц ашиглалт, орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Мөнх-Очир)-т даалгасугай.
3. Агнуурын нөөц ашигласны тайлан мэдээг цаг тухайд нь нэгтгэн холбогдох газарт хүргүүлэн ажиллахыг Байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232601010